

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-22</i>
<hr/>	
<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/</i>	<i>4-5</i>
<i>2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>5-22</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 18-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 22 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаатар, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн;  
Чөлөөтэй: Д.Өнөрболор;  
Тасалсан: С.Ганбаатар.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хуралдаанд оролцов.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал,

Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Л.Хурцбилэг, Редакц, кодификацын албаны ахлах зөвлөх Б.Батчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ж.Батжаргал, Д.Тогтохсүрэн, Ц.Сандаг-Очир, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 7  
Бүгд: 14  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 11 цаг 35 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 10 цаг 22 минут

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Нийт 19 гишүүн хуралдаанд оролцохоос ирсэн Ганибалын Амартүвшин гишүүн, Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа, Болдын Жавхлан гишүүн, Салдангийн Одонтүяа гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Шатарбалын Раднаасэд гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Ингээд нийт 10 гишүүн хүрэлцэн ирж, Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонхын ирц бүрдсэн тул 2023 оны 10 сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг та бүхэнд мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл,

2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 23 оны 09 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байгаад байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байхгүй тул хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**1. “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль, тогтоолын төслийн хэлэлцэх дарааллыг зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын даргаас сар бүр захирамжаар батална гэж, мөн зүйлийн 10.6 дахь хэсэгт энэ хуулийн 10.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороод баталж мөрдүүлнэ гэж заасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалтыг явуулж эхэлье.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 80 хувиар дэмжигдсэн байна.

10.25 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 2 дахь асуудал.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.**

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна. Жавхлан сайдыг индэрт урья.

**Б.Жавхлан:** Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Сүүлийн 3 жилийн хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахлын аюул, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдал, түүнээс улбаалсан инфляцын дарамт зэрэг гадаад хүчин зүйлээс шууд шалтгаалсан урьдчилан тааварлах боломжгүй бэрхшээлийг даван туулахад төсөв мөнгөний бодлогыг чиглүүлж, багц арга хэмжээнүүдийг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан үе шаттай авч хэрэгжүүлсний үр дүнд эдийн засаг цар тахлын өмнөх үед хүрч сэргээд байна. Тухайлбал, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын болон засаглалын оновчтой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдэж, улмаар гадаад валютын нөөц 23 оны 9 дүгээр сарын байдлаар 4,1 тэрбум долларт хүрч чадсан нь өмнөх оны мөн үеэс 1,3 тэрбум доллароор даруй нэмэгдсэн байна.

Түүнчлэн дэлхий дахинд үүсээд байсан хүнс, эрчим хүчний огцом өсөлтийн гадаад шокоос иргэдийн бодит орлого, амьжиргааг хамгаалах зорилгоор үнийг тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд инфляцын хурд харьцангуй удааширч, 23 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн 4,4 хувиар буурч, 10 хувьд хүрээд байна.

Дээр дурдсан эерэг хүчин зүйлсийн нөлөөллөөр эдийн засгийн өсөлт, инфляцын болон бусад эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн түвшин 23 оны төсвийн жилийн эцэст одоогийн хүчин төгөлдөр төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан 2024 оны суурь түвшинээс давахаар байна. Тухайлбал, 2024 оны батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд нүүрсний экспортын биет хэмжээ 50 сая тонн байхаар тооцсон хэдий ч 23 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар хэдий 51 сая тонн нүүрс экспортлон байна. Иймд 24 онд 60 сая тонн нүүрсийг экспортлох нөхцөл бодитоор бүрдээд байна.

Мөн уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр, худалдааны салбарын өсөлтийн нөлөөгөөр 2024 оны батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд 6,5 хувьтай тусгагдаж байсан эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч нэрлэсэн ДНБ-ий 74 их наяд төгрөгт байхаар төсөөлж байна. Тиймээс макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төсвийг бодлогыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас 23 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-26 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн зарим үзүүлэлтийг эдийн засгийн сэргэлттэй уялдуулан бодитой тооцон өөрчлөх шаардлага үүсэж байна.

Төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт орсноор ирэх 2024 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их

наяд төгрөг буюу ДНБ-ий 2,8 хувьд тус тус барихаар байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байгаа болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж, УИХ-аар хэлэлцүүлэх боломж олгоно уу. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн нэрсийг, албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даога Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Төсвийн

хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг гэсэн бүрэлдэхүүнтэй оролцож байгаа юм байна.

Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл хэлэлцэж байгаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас яагаад ганцхан албан тушаалтан байна. Дэд сайд, төрийн нарийн хаагуур байна. Хүрэлбаатар сайд гадагшаа томилолттой, Хятадад яваа юу. Дэд сайд, Төрийн нарийн хаа байна. Төрийн нарийн хаана байгаа юм. Дэд сайдаа дуудна аа. Төрийн нарийнаа, Төрийн нарийн хэзээ ирэх вэ? Төсвийн хүрээний мэдэгдлийг маргааш хэлэлцэхэд Төрийн нарийн, дэд сайд нар байна аа, сайд хэзээ ирэх вэ? Гол Эдийн засгийн хөгжлийн яамны гол хариуцах асуудлууд төсвийн хүрээнд мэдэгдэл байгаа шүү. Төсвийн шинэчлэлийн хуулиудын хүрээнд бас бид нар энэ зохицуулалт эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Хариуцлагатай хандана шүү. Холбогдох албан тушаалтнууд хуралдаа орж байна.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуулт асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгье. Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Бейсен гишүүний микрофоныг өгье.

**Б.Бейсен:** Та бүгдэд өглөөний мэнд хүргэе. Энэ 24 оны төсвийн төсөл дээр 6 сарын 15-нд бид нар санал өгсөн. Тэгээд ороогүй үлдсэн байх юм. Надаас нэг ч санал ороогүй юм. Тэгээд би саналаа энэ хурал давхцаж байгаа учраас саналаа хэлчхээд явчихмаар байх юм. Саналаа хүргүүлсэн. Бас орон нутгаар ажиллаж байгаад бас эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн чиглэлийн саналаа оруулсан нэг ч санал ороогүй байна. Үүнийг бас Сангийн сайд, Төсвийн байнгын хороо, ажлын хэсгийнхэн сайн харж үзээд тэрийг оруулж өгнө үү гээд хэлмээр байх юм.

**Г.Тэмүүлэн:** Бейсен гишүүн та төсөвтэй холбоотой, 2024 оны төсөвтэй холбоотой дотроо асуулт асууж байна тийм ээ? Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа. Маргаашаас эхлээд Улсын Их Хурлын чуулганаар төсвийн төслийг хэлэлцэж эхэлнэ. Тэр үед та бас хөндөж асуудлаа тавиарай гэж хэлэх байна.

Батжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25, 26 оны төсөөлөл орж ирж байгаа юм. Тэгээд энэ өмнө нь батлагдсан юун дээр өөрчлөлт оруулахаар орж ирж байна л даа. Тэгэхээр бид ДНБ-ийхээ өсөлтийг 7 хувиар тооцоод, тэгээд ер нь нэг 74 орчим их наяд байх нь ээ гэсэн ийм тооцооллууд гарч ирээд байна. Гадаад нөхцөл байдлыг ингээд хараад байхаар зэрэг дэлхийн эдийн засгийн өөрийнх нь өсөлт тэрний таталцал нөлөөлөл бидэнд ер нь ямархуу юм авчрах юм. Энэ талын нөлөөлөл дээр ер нь ямархуу тооцоолол хийгээд 0,5 функтээр нэмэгдэх бололцоо байна гээд оруулаад ирэв ээ гэдэг дээр нэг ийм зүйл байна гэж.

2 дугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль түүний тусгай шаардлагуудын тухай л асуудал байгаад байгаа л даа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дээд тааз руу юмнуудаа аваачиж тавьчихаад болж өгөхгүй байна аа бид. Ер нь бодит байдал дээрээ жосоохон ул суурьтай хандах тухай асуудлыг уул нь удаа дараагийн энэ хүрээний мэдэгдэл, төсөөлөл дээр яриад байгаа юм. Одоо жишээ нь бид төсвийн алдагдлаа 2,8 гээд л хэлчихээр зэрэг наадах чинь орлого, зарлага 2-ын харилцаа өсөөд л, яваад л, 2,8 болохоор биет хэмжээгээрээ нэмэгдчихээд л байгаа байхгүй юу. Бид 23 оны төсвөө 1,4 их наяд руу алдагдлаа оруулж, ер нь бараг энэ сүүлийн хэдэн жилд хамгийн бага болгож баталсан. Гэтэл одоо орж ирчхээд байгаа саналаар 2,1 болж орж

ирчхээд байгаа байхгүй юу. Биет мөнгөн илэрхийллээрээ. Тэгэхээр энэ алдагдлыг бид ингэж заавал нэмэгдүүлээд байх шаардлага байна уу? Энэнээс үүдээд энэ өр, зээлийн асуудал энэ бүх юманд сөрөг нөлөө үзүүлээд байгаа учраас үүнийгээ ер нь хүрч болсон тэр түвшиндээ хадгалах мөнгөн илэрхийллээр нь хадгалах тийм бололцоо боломжийн юм ер нь гарахгүй байна уу? Энэ дээр ер нь ямар тайлбар юмнууд байна вэ гэдэг асуудал.

Дараагийн нэг зүйл. Нэгэнт ДНБ-ээ бид нэлээн өөдрөгөөр төсөөлөөд өсгөчхөж байгаатай холбогдуулаад өрийнхөө таазыг хуулиар заагдсан хувь хэмжээний дээд таазанд аваачиж хийчхээд болж өгөхгүй байна л даа. 40 хэд энэ тэр гээд ингээд их наяд гээд аваачаад хийчхээд байдаг. Гэтэл бодит юун дээрээ 30 хэдтэй, 30-тай одоо бараг энэ энэ чинь 7 сард яригдаж байсан яриагаар хүлээгдэж байгаа гүйцэтгэлээрээ бараг 29 рүү ороод ирж ч болохоор тухай яригдаад байсан. Тэгэхээр энэ асуудлууд дээр нэг тодорхой тайлбар аваад ер нь бас 1 нэгдсэн байдлаар ойлгож, энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудын таазаар нь ярьдаг биш бодит байдлаараа ярьдаг юм руугаа ер нь шилжиж болохгүй юм уу?

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Би 2 дугаар асуултад нь хариулъя. 1 дүгээр асуултад Эдийн засгийн хөгжлийн яамнаас хариулна байх. Төсвийн хүрээний мэдэгдэлд бид гол нь 9 макро тоогоо авч үздэг байгаа. Эндээс төсвийн тусгай шаардлагын 2 гол тоо байгаа. Энэ нь төлбөрийн тэнцэл сүүлийн жилүүдэд бид алдагдалтай явж байгаа учраас алдагдлын хязгаар гэсэн үг. Мөн өрийн тааз хязгаар. Төрийн энэ төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагуудыг бид төсвийн хүрээний мэдэгдэл дээр огт өөрчилдөггүй. Ер нь бидний чанга баримтлах гол макро



хязгаар тоонууд маань энэ. Тэгэхээр нэгэнт төсвийн тусгай шаардлага дээрээ хязгаар тоо гэж байгаа учраас бид төсвийн хүрээний мэдэгдэл буюу төсвийн хүрээний энэ чинь өөрөө бас л хязгаар юм байгаа юм. Тэгэхээр энэ хязгаараа барьж орж ирээд тэгээд энэ хүрээндээ төсвийнхөө тоонуудыг бариад явах нь л бидэнд эрсдэл багатай л даа. Ялангуяа сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ л туллаа. Ковид биднийг ямар их өөрчлөлтийн өмнө аваачив, ямар том сорилтуудын өмнө аваачив. Жилээр биш, улирлаар биш, өдрөөр, 7 хоногоор эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж байлаа. Бид өмнө нь он гараад нэг сард тодотгол хийж байсан тохиолдол сүүлийн 30 жилд байгаагүй. 22 онд бидэнд ийм зүйл тохиолдож л байсан.

Тийм учраас ялангуяа манай эдийн засгийн бүтэц маань бол хэврэг хэвээрээ л байгаа. Энэ эдийн засгийн өсөлт бол бас л маш хэврэг. Бид дотоод асуудлуудаа зохицуулж чадаад байна, болоод байна. Харин гадаад шокоос хэт хамааралтай ийм эдийн засаг, ийм эдийн засгийн тэлэлттэй байгаа үед бид тодорхой хэмжээний бас эрсдэлийн буфертэй явахгүй бол болохгүй. Тэгэхээр гүйцэтгэлээ мэдээж бид аль болох сайжруулж гаргахыг хичээж ажилладаг. 22 оны жишээ байна, бид 2,4 их наядын алдагдлын төсөв хууль батлуулсан. Гүйцэтгэл 1,6 их наяд гарсан. Ингээж бид нар сайжруулж гарсан, хязгаараа барьж гарсан, хязгаар дотроо төсвөө сайжруулаад гарсан гэсэн үг.

Өрийн таазын хувьд ч тэр бид өнгөрсөн жил 65 хувь барих ёстой 45 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Ирэх жил 60 хувийн хязгаартай гүйцэтгэл нэг 42 хувь байх болов уу гэсэн ийм зүгээр төсөөлөлтэй ийм байгаа. Ханишийн эрсдэл байна, мөн бусад өөр ч бидний төсөөлөөгүй эрсдэл гарч болзошгүй. Тийм учраас бол Засгийн газар өөрсдөө бид мэдээж тэнцлээ сайжруулж гаргах, гүйцэтгэлээ сайжруулж гаргахыг хичээж ажиллана. Тэгээд нэгэнт тусгай

шаардлагуудын хязгаар гээд заачихсан байгаа юман дээрээ бид төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ болбол энэ дээрээ тулгаад л өөрөөр хэлбэл бас эрсдэлээ ийм буфертэй орж ирсэн л гэсэн үг. Тийм. Баярлалаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас эдийн засгийн өсөлтүүдээ тайлбарлачихна биз.

**Г.Тэмүүлэн:** Эдийн засгийн хөгжлийн яам нэмж хариулъя. Хэдэн номер вэ, 2 номер.

**Л.Энх-Амгалан:** Эдийн засгийн өсөлтийн тооцоо болоод гадаад зах зээл дээрээс гадаад зах зээлийн нөхцөл байдлыг яаж харж байгаа тухай асуусан асуултад хариулъя. Өмнөх төсвийн хүрээний мэдэгдэл дээр 24 оны эдийн засгийн өсөлтийг 6,5 хувиар тооцож байсан, одоо 7 хувь гэж хэлж байгаа. Гарсан гол өөрчлөлт нүүрсний экспорт. Өмнө нь манайхаас нүүрсний экспортыг 50-55 сая тоннд гэж төсөөлж байсан бол одоо 60 сая тонн болгосон. Энэний цаана нь бол яг хил орчмын зохион байгуулалт, дэд бүтцийн хөгжил, экспортын тээврийн зохион байгуулалт сайжирсан. Үүнийг дагаад одоогийн нүүрсний гүйцэтгэл 51 сая тонн болчихсон байгаа. Эндээс хараад дараа жилдээ 60 сая тонныг экспортод гаргах бүрэн боломжтой гэж тооцоод эдийн засгийн өсөлтийн төсөөллөө өөрчилсөн байгаа. Ингээж өөрчлөхөд гадаад зах зээл дээрээс гол нь Хятадын эдийн засаг, Өвөр Монголын эдийн засаг ямар нөлөөтэй вэ гэдэг чухал. Хятадын эдийн засгийг барууны хэвлэлүүд 4,5-4,7 хувьтай өснө гэж төсөөлж байгаа юм. Хятадын албан ёсны төсөөлөл 5 хувьдаа хүргэж чадна гэсэн төсөөлөлтэй. Тэгээд дөнгөж сая өнөө өглөө Хятадын 3 дугаар улирлын ДНБ-ий гүйцэтгэл зарлагдсан, 4,9 хувь гэж зарлагдсан. Олон улсын шинжээчид 3 дугаар улирлын төсөөллийг 4,5 хувь гэж хэлж байсан. Тэгэхээр манайхны барьж байгаа бодлого Хятадын эдийн засаг ер нь өөрсдийнхөө тавьсан зорилтдоо хангалттай хүрнэ ээ гэдэг асуумжийг аваад явж байгаа.

Тэрнээс гадна бас Өвөр Монгол руугаа дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд нь нэлээд нэмэгдэнэ гэсэн бодлого бас баримталж явж байгаа, Хятад талаас. Тэр бас манай төсөлд бас эергээр нөлөөлж байгаа гэж харж байна.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Батжаргал:** Төсөөллөө бид их л зөв л харах ёстой л доо. 23 оныхоо ДНБ-ээ бид нэг 65 орчмоор тооцсон шиг санадаг юм. Тэгээд 7-оор явахаар зэрэг наад 74-тэй чинь барьж байгаа юм уу, үгүй юм уу? Нэг ийм. Урдхыг чинь эдийн засгийн өсөлт тийм өндөр гарч чадах юм болов уу даа. Одоогоос 10 гаран жилийн өмнө дэлхийг хамарсан эдийн засгийн хямралд АНУ ер нь барилгын салбар ипотекеэсээ хамруулаад нэлээн хүнд байдал авчирсан. Энэ урдхыг чинь яг тэр салбар нь царцчихаад байгаа юм биш юм уу? Барилгынх нь салбарууд, тэгээд энэ ер нь энэ ирэх жил тэрний дараагийн жил энэ тэрт бидэнд нэлээн тийм нөлөөлөл авчирна. Би тэгж л төсөөлдөг. Үүнийг юу гэж харцгаагаад байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулъя. Батжаргал гишүүний асуултад Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Тийм, Эдийн засгийн хөгжлийн өмнөөс дутуу хариулаад байх юм. Ийм байгаа, Батжаргал гишүүн ээ. Сая биет хэмжээнүүдийг ярьчихлаа. Тэгэхээр энэ жилийн төсөөлөл бол 60 их наяд хүлээлт, гүйцэтгэлээрээ тэгж гарахаар байна. Ер нь 61 орчим гарах болов уу. Хойтон 74 гэхээр 14 их наядын зөрөө, 60 гэсэн суурин дээрээсээ харах юм бол 21 хувь. 21 хувийнх чинь бол 10 хувь нь инфляцаар тайлбарлагдана. 10-11 хувь нь цэвэр яг эдийн засгийн өсөлт буюу дефлятор юм байгаа юм. Ийм дефлятор байгаа юм. Тэгэхээр энийг одоо юу гэдэг юм. Сонгуулийн жилийн хөөсрөлттэй хэт өөдрөг байна гэж бас шүүмжлэх эдийн засагч нар байгаа. Бас ингээд яг тооноос нь харах юм бол тэгж

харагдахаас өөр аргагүй. Гэхдээ ингээд задлаад ингээд анатомиор нь харах юм бол харин ч нэлээн тийм даруухан төлөвлөсөн тоонууд байгаа. Бид 22 онд анх удаа экспорт, импорт, гадаад худалдаанууд маань 2 ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайдын минутыг нэмээд өгье.

**Б.Жавхлан:** Тэгэхээр экспортын биет хэмжээнүүд бол харин ч маш даруухан байгаа. Яг зэсэн дээр ч тэр, төмрийн хүдэр дээр бид нар бүр багасгаж тооцсон байгаа шүү. Нүүрс дээр бол энэ жил бол 60 сая бол нэлээн дөхөөд гарчихаар байгаа. Тийм учраас энэ жилээсээ бууруулахгүй. Үнийг нь бол бид 140 гээд сүүлийн 3 жилийн дундаж үнээс зах зээлийн үнээ бид нар бол багаар авсан байгаа, 140 гэдэг бол багаар. Тэнцвэржүүлсэн үнэ нь бол 180 гээд бүр өндөр байгаа шүү дээ. Тэгээд тэнцвэржүүлсэн үнэ зах зээлийнхээ үнэ 2-оо бид нар аль багаар нь буюу 140-өөр авч байгаа. Тийм учраас энэ бол аль болох хөөсрөлтгүй, эрсдэл багатай ийм өсөлтийн тооцооллоор гарч байсан ийм дүн байгаа. Тийм учраас зүгээр яах вэ, урд Хятадын эдийн засгийн өсөлт энэ жил яах вэ саарлаа гээд 0,5 хувь дотор л хэлбэлзэж байгаа. Гэсэн хэдий ч манай эдийн засаг өсөлттэй байна. Өөрөөр хэлбэл энэ том эдийн засаг бүр хасах руу орчихгүй л бол энэ тодорхой хэмжээний өсөлт нь бид нарыг бол хэд дахин чирээд л аваад явчих юм байгаа юм. Тухайлбал нүүрс 3,4 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг шүү дээ, жилдээ 3,4 тэрбум тонн. Одоо бид нартай түншлээд байгаа Чайна Энержи гэж компани зөвхөн нэг энэ компани 700 сая тонн жилийн хэрэглээ нь. Тэгэхэд бид нар нэг компанийнх нь 10 хувьд нь хүрэх үү, үгүй юу л ийм нүүрс экспортолж л гэж байгаа юм. Хятадууд бид одоо харин тийм, байж бай, би тэрийг чинь хэлнэ. 3 удаа бид нар дээд хэмжээний айлчлал хийсний уулзалт бүр дээр манайхаас ямар хэмжээгээр экспортолж авчирч чадах вэ тэр хэмжээгээр чинь бид нараас авна аа л

гээж байгаа юм. Одоо яг л тэр хэлсэндээ урд талд яг л тэгж явж байгаа. Тийм учраас бид ирэх жилийн бол гол сорилт бол энэ бид биржээрээ худалдаалаад хил дээрээ хүргэж өгөх нь биднээс хамааралтай л ийм л эрсдэл байгаа.

**Г.Тэмүүлэн:** Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. 2024 оны улсын нэгдсэн төсөвтэй холбогдуулаад төсвийн хүрээний мэдэгдэл 24 оны, 25, 26 оны төсвийн төсөөлөл хэлэлцэж байна. Тэгээд энэ эдийн засгийн их чухал тооцоолол л доо. Уул нь ч бид нар үүнийг нэг өөрчлөөд байхгүй, тэгээд яг эндээ багтааж л төсвөө боловсруулаад л явах л ёстой л юм л даа. Тэгээд сүүлийн үед байнга төсөвтөө тохируулаад л бодит байдалтайгаа тохируулаад л ингээд өөрчлөөд явдаг л нэг ийм жишиг тогтчихоод байгаа юм. Бид өнгөрсөн жилээс эхлээд Эдийн засгийн хөгжлийн яам ажигласан. Шинэ онд. Энэ 9 үзүүлэлт дотор хамгийн 2 том үзүүлэлт нь Эдийн засгийн яамны гаргадаг ийм үзүүлэлт байгаа. Эдийн засгийн хөгжлийн яам бол Сангийн яамныхаа үгээр биш бие дааж эдийн засгийн прогнозоо тодорхойлж явах ёстой. Тэгээд би 1 дүгээрт, энэ эдийн засгийн өсөлт асуух гэж байгаа юм. Эдийн засгийн өсөлтийг 7 хувь гэж 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр орж ирсэн байгаа. Энэ ОУ-ын байгууллагын гаргасан тоогоор үзэхээр бас бодож үзмээр юмнууд харагдаж байгаа. Тухайлбал ОУВС бол манай улсын эдийн засгийг нэг 4,5 хувь өснө гэж тооцсон байна. Дэлхийн банк 6,3 хувь өснө гэж тооцсон байна. АХБ 6 орчим хувь өснө гэж тооцсон байна. Монголбанк бас нэг 6 хувь өснө өө гэж тооцсон байна. Эдийн засгийн хөгжлийн яам 7 хувь өснө өө гэж төсвийн төсөөллийг би бол энэ Эдийн засгийн хөгжлийн яаманд тавьсан тоо гэж ойлгоод байгаа шүү дээ. 7 хувь гэж оруулж ирсэн байна. 7 хувийн бодитой энэ талаар л би асуух гэж байгаа юм.

Хэрэгжих боломж бодитой юу гэж асуух гэж байгаа юм? мэдээж сая Жавхлан сайд хариулаад л байна. Нүүрснийхээ 50 сая тонн нүүрс олборлохоо 60 болгочихсон, тэгээд болчих байх л гээд байна. Нөгөө бусад талаас нь ер нь яаж авч үзэж байгаа юм бэ? Эдийн засгийн яам. 1 дэх асуудал энэ.

2 дахь нь инфляц. Хамгийн чухал юм инфляц байгаа юм. Бид чинь инфляцад нэг 10 хувиа идүүлчхээд байгаа байхгүй юу. Сүүлийн 22 он, 21 онд чинь бид нар бүр 15, 6 хүрээд инфляцад идүүлчихсэн байхгүй юу. Тэгэхээр энэ 23 онд бол, 24 онд 8,5 хувийн инфляцтай байна аа гэж Эдийн засгийн хөгжлийн яам тооцсон байна л даа. Энэ яг бодитой тоо юу, боломж байна уу гэдэг асуудал байгаа. Одоо бол нэг 10,5 хувьтай байна шүү дээ. 10 хувьтай байна, одоо. Тийм, тэгээд инфляц бол хамгийн чухал. Тэгээд би энэ инфляцтай холбоотой асуух гээд байгаа асуулт нь юу байна вэ гэхээр инфляцад идэгдээд байгаа энэ иргэдийн орлогыг л бид нар гол нь инфляцаас л хамгаалах ёстой. Энэ болбол энэ төрийн үндсэн том үүрэг. Иргэдийг өнөөдөр хамгийн анхаарал татаж байгаа асуудал бол ерөөсөө инфляц. Манай сумд ямар барилга баригдах нь вэ, манай дүүрэгт ямар зам тавигдах нь вэ асуудлаас илүүтэйгээр инфляц гэдэг энэ зүйл энэ жил хэдээр тавигдах нь вэ бидэнд яаж нөлөөлөх нь вэ л гэдгийг л хардаг болсон. Тэгэхээр би инфляцын бодитой эсэх тухай асуудал чухал байгаа юм.

Нөгөө талаас нь энэ инфляц, мөнгөний бодлого 2-ын уялдаж байгаа төсөв мөнгөний бодлого 2-ын уялдаж байгаа асуудал байгаа юм. Төсөв нэлээд тэлсэн. Зарлага нь тэлсэн, орлого нь тэлсэн, хөрөнгө оруулалт нь тэлсэн. Энэ нь нөгөө талдаа мөнгөний бодлогодоо сөргөөр нөлөөлдөг. Валютынхаа хани нөөцөд нөлөөлдөг. Тэгээд үүнийг хэр бодитой тооцож авч үзсэн бэ гэдгийг л би инфляц дээр 2 дугаарт нь асууя аа гэж бодож байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас ийм 2 асуултыг асууя.

**Г.Тэмүүлэн:** Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яам 2 номер.

**Л.Энх-Амгалан:** Эдийн засгийн өсөлтийн тухайд 7 хувийг нэлээд бодитой тооцоо гэж нэлээд бодож тооцож хийсэн байгаа. Гол гол томоохон ААН байгууллагуудтай уулзсан. Тэдний бизнес төлөвлөгөөг хийх гэж байгаа ажлынх нь төлөвлөгөөнүүдийг харсан. Экспортынх нь төлөвлөгөөг бас авч үзсэн. Уул уурхайн гол эдийн засгийн өсөлтийг дэмжих салбар бол уул уурхайн салбар. Уул уурхай нийт 17 хувиар өснө. Ингэж өсөхөд түрүүн хэлсэн нүүрсний экспорт чухал. Мөн Оюутолгой дээр одоо яг ашиглаж байгаа хэсэгтэй холбоотойгоор агууламжууд их сайн нэмэгдэж байгаа. Алтны агууламж, зэсийн агууламж, бүгд нэмэгдэж байгаа. Тэгэхээр эд нар мөн уул уурхайн салбарын өсөлтийг өндөр байхад нөлөөлж байна. Уул уурхайн бус салбарын хувьд 5,5 хувиар өснө гэж тооцож байгаа. Уул уурхайн бус салбар дотор гол нь гэвэл тээврийн салбар байна. Экспортын өсөлтийг дагаад тээврийн үйл ажиллагаа тогтвортой сайн байна гэж харж байна. Дагаад мөн худалдаа үйлчилгээний салбар өсөлт нь өндөр байна. Тэгэхээр 7 хувь ер нь тийм өөдрөгтөө орохгүй. Ер нь бодитой тооцоо гэж харж байна.

Инфляцын тухайд инфляц төсөв тэлж байгаатай холбоотой инфляц дээр дарамт ирж байгаа. Мөн гадаад зах зээл дээрээс ч мөн зарим импортын бараатай холбоотой инфляцын дарамт өндөр байгаа. Гэхдээ засаг дээр ямар ажил хийж байна гэхээр гол гол бараа бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх дээр одоогоос тогтоол гаргаад, арга хэмжээнүүд аваад хэрэгжүүлээд явж байна. Махан дээр махны нийлүүлэлтийг яаж нэмэх вэ, малын зах, махны захыг яаж оновчтой зохион байгуулж ажиллуулах вэ, махны нийлүүлэлтийг яаж зөв хийх вэ гэдэг дээр

бас нэлээд анхаарал тавьж ажиллаж байгаа.

Эм дээр мөн адилхан худалдан авахын хуульд эмийн худалдан авалттай холбоотой зохицуулалтууд орсон. Үүнийг дагаад яг гол өргөн хэрэглээний импортоор авдаг эмийн үнэ, зохион байгуулалт илүү сайжирна гэж харж байгаа. Энэ яг өрхүүдийн бодит орлогыг хамгаалах, зарлагыг бууруулахад чухал арга хэмжээ болно гэж үзэж байна.

Бас зарим хүнсний барааны үйлдвэрлэл, нийлүүлэлт нэмэгдэнэ гэж харж байгаа. Өнгөрсөн жилийн төсвийн хуулийг дагаад хүнс, хөдөө аж ахуйн салбарын тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлсөн. Үүний үр дүнд нь яг тэр салбарын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, импорт нэлээд нэмэгдсэн байгаа. Тэгэхээр энэ нь өөрөө хүнс, хөдөө аж ахуйн чиглэлд боловсруулах үйлдвэрлэл нэмэгдэх мөн бүтээгдэхүүний нийлүүлэлт нь нэмэгдэнэ гэж ингэж төсөөлж харж байгаа. Тэгээд жилийн дунджаараа инфляц ирэх жилдээ 8,5 хувьтай явчих болов уу гэж харж байгаа юм. Тэгээд ингэж харахад бас гишүүний хэлсэн тэр мөнгөний бодлого чухал нөлөөтэй. Мөнгөний бодлого дээр төсөөлөл хийхдээ одоогийн байгаа нөхцөлөөсөө сулрахгүй гэсэн таамаглал тавиад тооцоо хийсэн байгаа. Тэгэхээр цаашидаа инфляц ингэж хадгалагдахад мөнгөний бодлогын тохируулга бас их чухал нөлөөтэй гэж хэлье.

**Г.Тэмүүлэн:** Тогтохсүрэн гишүүн нэмж тодруулъя.

**Д.Тогтохсүрэн:** Инфляцад чинь хамгийн гол нөлөөлж байгаа юм чинь нефтийн бүтээгдэхүүн байхгүй юу. Та нар бол энэ тооцооллоо хэр зөв хийж байгаа юм бэ, бүү мэд. Би тэгж л харж байна. Одоо энэ 10, 11 сард бол маш өндөр гарна шүү дээ. Инфляц чинь. Нэмэгдэнэ шүү дээ. Жишээ нь нефтийн бүтээгдэхүүн буюу дизелийн түлшний

өвлийн дизелийн түлшний үнэ чинь бараг 20 гаруй, 30-аад хувиар нэмэгдсэн юм шиг байна шүү дээ. 3100-гийн бүтээгдэхүүн чинь 3800, 900 хүрчихлээ гээд ингээд бизнесүүд тэгээд байна, дизелийн түлшийг ярьж байна, би. Энэ чинь хамгийн том инфляцын асуудал байхгүй юу. Тэгээд энэ Эдийн засгийн хөгжлийн яам та нар энэ УУЯ эд нартай ярьж байгаад хамгийн чухал нь энэ дизель биш ээ, энэ нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг яаж нэмэгдүүлэх вэ? Энэ нефтийн бүтээгдэхүүнийг өөр эх үүсвэрээс яаж олж болох вэ? Бид чинь ганцхан эх үүсвэртэй. Дураа хүргэхээр яваад дургүйгээ хүргэхээр хаагаад хаячихдаг нэг эх үүсвэртэй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлээр урагшаагаа бид нар түүхий нефть гаргаж байна. Урд хөрштэйгөө бид нар түүхий нефтээ ярилцаад тэндээс шатахуун оруулж ирэх талаар ярьж хөөрөх, өөр эх үүсвэрүүдийг судлах ийм чиглэлээр ер нь манай Эдийн засгийн хөгжлийн яам, УУЯ ажиллаж байгаа юм байна уу? Одоо бид нар хамгийн барьцаанд байгаа юм бол энэ нефтийн бүтээгдэхүүн л болчихоод байна шүү дээ. Хэрэглээ нь байнга өсөн нэмэгдэж байдаг, байдаг доллароо энд өгчихдөг. Тэгээд валютын хани нь өсөөд байдаг. Байдаг инфляц нь энэ дээр явчихдаг нэг ийм л болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр өөр эх үүсвэр, өөр гарцуудыг л бид нар хайхгүй. Тэгээд л нэг мах өссөн, төмс өслөө, нэг юм өслөө гээд энэ бол нэг тийм байхгүй юу. Энэ том юмаа ингэж харж авч явах асуудлаар л бид нар энэ Эдийн засгийн хөгжлийн яамыг онцгой анхаарах ёстой. Уул нь макро эдийн засгийн бодлогын газар гээд гол газар нь байна л даа. Энэ мэргэжлийнх юм уу, үгүй юм уу мэдэхгүй.

**Г.Тэмүүлэн:** Эдийн засгийн хөгжлийн яам асуултад хариулъя. 2 номер.

**Л.Энх-Амгалан:** Шатахуун дээр 92 дээр хэлцэлтэй байгаа учраас үнэ нь гайгүй. Дизель дээр гишүүний хэлсэнтэй

яг санал нэг байна. Дизелийн үнэ өсөж байгаа нь ялангуяа манай хөдөө аж ахуйн салбараар дамжаад инфляц болоод бизнесүүдийн зардал өсөхөд их сөргөөр нөлөөлж байгаа. Дизель дээр тэгээд УУЯ, манай яам хамтраад эх үүсвэрийг нэмэгдүүлэх тал дээр ярилцаж байгаа гэж ойлгож байгаа байна.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

**Ц.Сандаг-Очир:** Энэ Их Хурал, энэ Засгийн газар 3, 4 дэх жилийнхээ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллөө хэлэлцэж байна. 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл ер нь өмнөх Засгийн газар, Сангийн яамны 3 жилийн өмнөх, 2 жилийн өмнөх, 1, жилийн өмнөх төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төсөөллүүд чинь ер нь нийцэл нь хэр байгаа вэ? Жишээ нь та бүхэн 24 оны төсвийн төсөөллийг 22 онд, 23 онд Төсвийн хүрээний мэдэгдлийг бас л ингээд л таамаглаад л төсөөлөөд л байж байсан байх. Тэр төсөөлөл, таамаглалууд чинь ер нь хэр нийцтэй байгаа вэ? Хэр хол зөрж байгаа вэ? Эндээс юу хэлэх гээд байна вэ гэхээр та бүхний ер нь таамаглал, төсвийн хүрээний мэдэгдэл төсөөллүүд чинь ер нь хэр ойрхон байна вэ? Хэр сайн тооцоолж байна вэ? Зүгээр жил болгон ингээд л нэг төсөөлөл гээд л ингээд л нэг таамаг төдий юм ингээд яваад байдаг. Энэ ер нь хэр бодитой юм? Та бүхний сайн төсөөлсөн, сайн тооцсон бол энэ тоонууд ойрхон л очиж байх ёстой байх. Үүнийг нэг асууя.

2-т, жил болгон энэ төсөв дээр л миний эмээдэг зүйл энэ өр зээлийн л асуудал. Тэгээд 3 жилийн өмнө бид нар нэг 18, 19 их наядын орлого л ярьдаг байсан. Өнөөдөр 3 жилийн дараа, 4 жилийн дараа ингээд 25 их наядын орлого, 27 их наядын зардал яриад л сууж байна. Орлогоо нэмэгдүүлээд, зарлагаа нэмэгдүүлээд ингээд төсөв тэлж байгаа ч гэсэн яг бодит утгаараа улс орны ард иргэдийн амьдралд яг наалдацтай нь юу байна вэ? Орлогоо нэмэгдүүлэхийн хэрээр зардал маань тэр хэрээрээ өсөөд байгаа

учраас эдийн засгийн өсөлт чинь бодит байж чадаж байна уу, үгүй юү гэдгийг л харах гээд байгаа юм. Яах вэ, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд бас нааштай ахиц өөрчлөлтүүд харагдаж байгаа нь үнэн. Цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлж байгаа. Одоо тэр битгий хэл 6 сарын дотор ахиад нэмэгдүүлэх ийм төлөлт орж ирээд явж байгаа юм. Гэхдээ бид нарын тооцоолсон шиг яг энэ нэмэгдлүүд бас ард иргэдэд тэр болгон авч байгаа нэмэгдлүүд нь амьдрал ахуйд нь хүрэлцэх хүрэлцээ хангамж юу билээ гэж.

Инфляцынхаа өсөлтийг гүйцэж чадахгүй байгаа учраас энэ нэмэгдлүүд бас бодит болж чадахгүй байна. Тийм учраас ирэх жилийн төсөв дээр зардлыг бууруулах тал дээр, тэвчих тал дээр яаж анхаарсан бэ? Орлого нэмэгдэхийн хэрээр зардлаа нэмэгдүүлчихвэл энэ чинь ямар ч ялгаа харагдахгүй байгаа. Тийм учраас зардлыг тэвчих, бууруулах тал дээр, төсвийн алдагдлыг яаж нөхөх гэж байна вэ? Ирэх жил хаанаас аль гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагаас хэдий хэмжээний зээл авах гээд гэрээ хэлцлүүд хийгдэж байгаа вэ?

Нөгөө талаар ойрын хугацаанд бас томоохон төслүүд хэрэгжиж эхлэх юм байна. Гэрээ хэлцлүүд явагдаж байна. Энэ нь төсөвт эргээд яаж нөлөөлөхөөр байна вэ? Үүнийг бас нэг та бүхэн хэлж өгөөч ээ гэж ингэж бодож байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Жавхлан сайд асуултад хариулъя.

**Б.Жавхлан:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Сүүлийн жилүүдэд хийгдэж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл маш сайн хийгдэж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлүүд мэдээж тоонууд нь өөрчлөгдөж орж ирж байна. Энэ дандаа сайжирч орж ирж байгаа шүү. Энд бид нар энэ

төсвийн хүрээний мэдэгдэлд байдаг 9 тоо байгаа юм, 9 тоогоос 2 нь Төсвийн тогтвортой байдлын хууль дээр байдаг тусгай шаардлага юм байгаа юм. Энийгээ бид нар бол ягштал барих ёстой. Бусад тоонууд бол эдийн засгийн тэлэлт буюу ДНБ өссөнтэй холбогдуулж хувь хэмжээнд ноогдох номинал дүнгүүд нь өөрчлөгдөж ингэж орж ирж байгаа юм. Үүнийг бид нар тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, өөрчлөлттэй холбогдуулж үүнийг өөрчлөөд явах нь бол зөв. Тэрнээс биш тооцооллыг дутуу хийгээд муудаж орж ирээд, орлого нь зарлагаа санхүүжүүлж чадахгүй, төрийн үйл ажиллагаа доголдох хэмжээний тийм зөрөө тооцоолол огт байхгүй ээ. Тийм учраас Төсвийн хүрээний мэдэгдлийн энэ тоонууд бол сүүлийн жилүүдэд бол маш сайн хийгдэж байгаа гэж хэлмээр байгаа юм.

Ер нь яах вэ, эдийн засгийн өсөлт, тэлэлт бол манай орны эдийн засгийн өөрийн бүтэцтэй их холбоотой байна. Бид манай эдийн засаг маань гадаад шок, гадаад нөхцөл байдлаас хэт их хамааралтай болж ирсэн. Үүнийг бид нар тэр болгон удирдаж чадахгүй. Дотоод асуудлаа бид нар зохицуулаад байгаа, дотоод асуудлаа зохицуулж чадаж байгаа учраас сүүлийн жилүүдэд эдийн засаг маань тогтворжиж ирлээ. Төсвийн алдагдал буурч ирлээ. Ийм сайн үр дүнгүүд гарч ирж байгаа. Гадаад нөхцөл гадаад шокийг бид нар яаж ч чадахгүй. Энэ ковидыг, энэ дайныг, энэ Палистины асуудлыг, үүнийг дагасан бензин шатахууны өөрчлөлтүүд орж ирэх юм бол бид үүнийг зохицуулж чадахгүй шүү дээ. Тийм учраас энэ бүгдийг дандаа нөөцтэй төлөвлөж байгаа гэсэн үг. Нөөцтэй. Орлого нэмэгдэнэ түүгээрээ бид нар алдагдлаа бууруулна. ДНБ нэмэгдэнэ тэрийг дагасан төрийн үйлчилгээний зардал нэмэгддэг. Ийм л зүй зохистой явж байгаа.

Төсөв тэлж байгаа, төсөв тэлж байгаа хэрээр бид хамгийн түрүүнд төсвийн бодлого төсвийн дамжиж ард

иргэд, өрхийн орлогыг дэмждэг хамгийн гол суваг цалин, тэтгэвэр тэтгэмж энэ халамж л байдаг. Төсвийн орлого нэмэгдсэн. Бид нар хамгийн эхний боломжоороо өрх амьжиргааны түвшнийг сайжруулдаг. Энэ дээрээ бид тодотгол хийсэн. 33 жилийн түүхэнд анх удаа төсвийн орлогынхоо давсан хэмжээгээр бид тодотгол хийсэн байгаа юм. Энэ удаа. Ирэх жилийн төсвийн нэмэгдэл нийтдээ 4,9 их наядын маань 3,4 их наяд нь энэ жилийн бид нар хагас жилээр хийсэн төсөв юу, цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэл нь хойтон жил бүтэн жилээр тооцохоор ингээд даблдаж орж ирж байгаа ийм л зүйл байгаа. Тэрнээс биш төсөв хөөсрөөд хийсэн юм юу ч байхгүй.

Дээрээс нь дандаа хуулийн өөрчлөлтөөс нөлөөтэй бас нэмэгдлүүд байгаа. Боловсролын хууль, Нийгмийн даатгалын багц хууль байна. Нийгмийн даатгалын багц хуулиар зөвхөн 480, зөвхөн энэ багц хуулиар 482 тэрбум төгрөгийн нэмэгдэл орж ирж байгаа шүү дээ. Боловсролын хуулиар байна. Нөгөө сонгуульд зориулсан төсөв, нөгөө бүтээн байгуулалт юмнууд нь баахан цэцэрлэг, сургууль барилаа л гэж байгаа. Энэ 4,9 их наядын дөнгөж 300 тэрбум нь л өнгөрсөн оныхоос өссөн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн хөрөнгийн зардлын нэмэгдэл байгаа.

Тэгэхээр ирэх жилийн энэ төсвийн өөрчлөлтүүд, төсвийн тэлсэн байгаа энэ байдал бол яг бодит эдийн засгийн өсөлттэйгөө уялдаатай. Харин ч хөөсрөлт багатай ийм бодитой өсөлт болсон байгаа. Та цалин ярьж байна. Цалинг мэдээж инфляцтайгаа бид уялдуулж явах ёстой. Гэхдээ бид чөтгөрийн тойрог руу явж орж болохгүй. Цалин тэтгэврээ нэмдэг, инфляцыг хөөрөгдүүлдэг, буцаагаад дотоод бодлогын хүүгээ нэмэх болдог, эдийн засгаа боомилдог ийм чөтгөрийн тойрог руу явж орж болохгүй. Ковид, энэ дайнтай холбоотой бид сүүлийн 3 жил 19 он хүртэл цалингаа нэг 6-7 хувь, 8

хувь зарим жил нэмдэг байсан тэр жишгээрээ нэмж чадаагүй, нэмж чадаагүй. Өөрөөр хэлбэл тэр талаас нь инфляцын хөөргөдөл бага байсан гэсэн үг. Харин сая эхний боломжоороо бид нар нэмлээ. Гэхдээ бид инфляц яг бууж байх хэмжээнд, тэр циклтэй таарч энэ нэмж байгаа. Тэрнээс биш инфляц өндөр байхад 15, 6 хувь байхад энэ цалин тэтгэврээ юу юугүй нэмээд буцаагаад инфляцаа хөөргөчихье гэсэн ийм бодлоор яваагүй, боломж ч байгаагүй. Тийм учраас энэ удаа яг цалингаа бид инфляцын яг бууж байх энэ мөчлөгтөө тааруулж, тэгээд Нийгмийн даатгалын багц хууль дээрээ хүртэл бид нар бүр хуульчилчихсан шүү дээ. Та нар энэнээс хойш инфляцтай уялдуулж жил болгон бүр нэмнэ шүү гээд хуульчилчихсан. Энэ хуулийн дагуу л бид 10 хувийн нэмэгдэл оруулж ирж байгаа. Гэхдээ үүнийг нь бас инфляцтай уялдуулж, 07 сарын 01-нд нэмсэн, тодотголоор. 8 сарын эффект нь орж 8 сараас цалингийн тэтгэврийн эффект орж ирж байгаа. Эндээс хэдхэн сарын дараа 3 дөрөвхөн сарын дараа 01 сарын 01-нээс хэрвээ нэмэх юм бол инфляцтай уялдуулж нэмэх биш харин ч бүүр инфляцтай хөөрөгдсөн ийм асуудал болно. Тийм учраас инфляцын эффектийг нь гаргаад, ядаж 6 сарын дараа буюу 04 сарын 01-нээс нэмж байгаа. Ингэхээр энэ болбол яг инфляцтайгаа уялдуулж, мөнгөний бодлоготойгоо уялдуулж, мөнгөний бодлогоос тавьж байгаа бас яг энэ шаардлага яг хэлэлцэж байгаа үед гишүүдийн ярьж байгаа хэлж байгаа зүйлүүдийг бас та бүхэн бүгдээрээ сонсож байгаа байх. Энэ бүх зүйлтэй уялдуулж ингэж орж ирж байгаа.

Тэгээд эдийн засгийн өсөлт дотор түрүүн Эдийн засгийн хөгжлийн яамныхан хэллээ. Тээврийн салбарын нэлээн өсөлт байгаа юм. Тээврийн салбарын өсөлтөө дагаад маш олон ААН-үүдийн энэ дээр ашиг, орлого нэмэгдэж байгаа. Энэ дээр дамжаад цалин хөлс, худалдан авалтаар маш их ийм эдийн засгийн өсөлтийн яг өрхийн хэмжээнд хүн амын яг орлогын түвшинд очиж

байгаа ийм сувгууд маш сайн тэлж өгч байгаа. Энэ нь хойтон хийгдэх таны асууж байгаа тэр томоохон хэрвээ гэрээ, хэлэлцээрүүд УИХ-аар батлагдахад амжилттай хийгдэх юм бол яг энийгээ дагаад хамгийн түрүүнд тээврээр дамжаад ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Салбаруудын эдийн засаг өсөж байгаа. Харин уналттай байгаа салбар бол хөдөө аж ахуйн салбар шүү. 23 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй байдлаас болоод. Тийм учраас энэ хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг дэмжих бодлого юу байгаа вэ гэдгийг нэгд асууя.

Малын гаралтай бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур үнэ хүрэхгүй байгаа. Малчдын амьдрал ахуйд тэр нь сөргөөрөө нөлөөлж байгаа. Энэ дээр ирэх жилийн төсвийн хүрээний мэдэгдэлд хөдөө аж ахуйн салбарыг.

Аялал жуулчлал энэ жил харин харьцангуй овоо байсан байх гэж бодож байна. Аялал жуулчлалын төсвийн орлогод нөлөөлж байгаа байдал, нэмэгдлийг яаж тооцоолж байгаа вэ? Ер нь ирэх жил бас. Уг нь бол их бас төсвийн орлогыг нэмэгдүүлэх бас нэг салбар бол аялал жуулчлалын салбар юм байна шүү дээ. Энэ жил харьцангуй бас Монголд зочлох жилийн хүрээнд жуулчид хэдэн мянга ирэв. Ирэх жил яаж төсөөлж байна, аялал жуулчлалын салбараас орох орлогыг.

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэглэлээр энэ НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгоно гэсэн. Энэ асуудал. НӨАТ-ын миний ойлгосноор нэг төсөвт 4, 5 их наядын орлого орж байгаа байх. Тэгвэл 5 хувийн буцаан олголт нь энэ нь эргээд төсөвт орлогод яаж нөлөөлөх юм, эерэг, сөрөг тал нь. Хүндрэл нь. Энэ дээр та бүхэн бас нэг

хариулт тайлбар хэлэх юм юу байна? Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Асуултад хариулъя, Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Манай хөдөө аж ахуйн салбар бол уламжлалт эдийн засгийн маань бүтэц ээ. Гэсэн хэдий ч ер нь төсвөөс дэмжлэг татаас их шаарддаг, шингээдэг ийм салбар. Гэсэн хэдий ч бас асуудлууд нь бүрэн шийдэгдэхгүй л явсаар өнөөдрийг хүртэл ирсэн. Цаашидаа ч иймэрхүү байдлууд ойрын жилүүдэд хадгалагдахаар байгаад байгаа юм. Энэ дээр бид нар дорвитой, шүүмжлэлтэй хандаж, өөрчлөлт хийх цаг нь болчихсон. Ялангуяа МАА-н салбар дээр. Бидний мал уламжлалт бэлчээрийн МАА-гаасаа суурин фермерийн МАА руу аажим аажмаар, бага багаар шилжиж байж л энэ том эрсдэлүүд нэг мөр шийдэгдэнэ. Тэрнээс биш бид нар одоогийнхоо ийм бүтэцтэй ингээд явах юм бол нэг өдөр дахин давтагдашгүй байгалийн хүчин зүйл гэж ярьдаг юм. Жил болгон л зуд болдог юм шүү дээ. Жил болгон л зуд болно, жил болгон л хавар хүндрэл болдог. Тэгэхээр бид нар том зургаараа ийм хөгжлийн шилжилт хийх хэрэгтэй. Яг үүний төлөө, яг ийм бүтцээр, ийм зорилгоор, хүнсний хувьсгалын зорилт ингэж явж байгаа шүү. Газар тариалан дээр ч тэр, МАА дээр ч тэр. Тэрнээс биш бид нэг жил болгон гал унтраасан нэг ийм юмнуудаа ярих юм бол улиг болсон юмнуудаа л ярина.

Өрийн хувьд бид Улсын Их Хурлаас баталж өгдөг 3, 3 жилийн стратегиа өөрөөр хэлбэл гэрийн даалгавраа гэсэн үг, Засгийн газар маш сайн чанд бариад явж байгаа. Энэ 3 жилийнхийг бид нар маш сайн барьсны үр дүнд энэ ковидын хүнд үед, ноднин жилийн өмнө ямар хүнд байлаа, эд нарыгаа бид ардаа үлдээсэн, амжилттай давсан. Энэ жил гэхэд бид Засгийн газрын гадаад өрөөс болж дефолт болох ийм эрсдэл өнгөрсөн оны



жилийн эцэст бодитойгоор нүүрлэсэн байсан. Ингээд бид Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын энэ хугацаанд нийтдээ 11,9 их наядын гадаад өрийг төлж зохицуулалт хийсэн байгаа. Үүнээс 4,8 нь дахин санхүүжилт, бусад нь 6 их наяд нь үндсэн өр буюу хүүгийн төлбөрийг бүрэн барагдуулсан ийм хүнд жилүүдийг бид амжилттай туулж байна.

Ирэх жилийн өр абсолют дүнгээр бол 3,1 их наядаар нэмэгдэнэ. Үүнээс 2,1 нь бол алдагдлаар, 1,1 нь нийслэлийн 500 тэрбумын бонд, мөн Дорнодын цахилгаан станц дээр бид тодорхой хэмжээний Засгийн газрын баталгаа гаргаж болзошгүй байгаа. Ийм дүнгүүдээр ирэх жилийн өрний өөрчлөлт ингээж байгаа.

Аялал жуулчлалын салбар энэ жил амжилттай явсан. Энэ дээр хамгийн гол нөлөөлсөн юм бол мэдээж ковидоо бид нар амжилттай даван туулсан. Энэ жилийн эдийн засгийн форумаа бид амжилттай хийлээ. Ингээд гадаад талдаа мессежнүүдийг их сайн өгсөн. Үүний үр дүнд Монгол руу чиглэсэн, Монголыг байгаагаар нь сонирхож ирэх гэсэн жуулчдын тоо нэмэгдсэн. Энэ дээр хамгийн гол зүйл бид энэ нисэхийн салбар дээр либералчилж явсан. Нисэхийн салбар дээр ганц МИАТ гэдэг төрийн өмчийн компани дээрээ тулгуурласан хэт монополжсон ийм авиа энэ сүлжээгээ сайн задалж чадсан. Үүний үр дүнд ч үнэ буурсан. Гадна талдаа үнэ буурсан, нислэг нэмэгдсэн. Одоо 7 хоногт 165 нислэг авч байгаа шүү дээ. Бид нар хэзээ ч ингээж байгаагүй. Энэ бол маш сайжирсан.

Дээрээс нь дотоодын нислэгүүд байна. Баруун аймгуудынх бүр сая 500-аас дээш байсан, үүнийг саяас доош буулгаж чадсан. Өөрөөр хэлбэл өрсөлдөөнийг сайн дэмжиж чадсан ингээж буулгасан. Ингээд дотоодын аялал жуулчлал ч тэр, гадаадын аялал жуулчлал ч тэр энэ жил сайн нэмэгдсэн. Ирэх жил бол дахиад одоогоор бол нэг

Аялал жуулчлалын яамнаас гаргаж байгаа тоогоор 500 мянгад хүрсэн байна. Бид нар энэ жил сая хүрнэ гэж тооцоолж байсан. Энэ нэлээн дөхөх байх. Яах вэ, бид нар сая гэж нэлээн амбицтай зорьсон. Зүгээр арай хүрэхгүй байж магадгүй, тэгэхдээ нэлээн дөхнө. Хойтон сая хүрнэ гэж харж байгаа юм.

Эдийн засгийн салбараар нь харах юм бол аялал жуулчлалын орлого гэж дан ганц ийм эдийн засгийн ангилал байдаггүй. Энэ чинь зочид буудал, үйлчилгээ, ингээд тээвэр гээд бүх юм руугаа тараад орчихдог учраас бүх салбар луу жигд нөлөөлдөг ийм манай эдийн засгийн өсөлтийн гол потенциалын ийм салбар байгаа.

НӨАТ-тай шулуухан хэлэхэд энэ ямар ч боломжгүй асуудал. Энэ бол ёстой жинхэнэ нөгөө сонгууль дөхсөн л ийм хэрэг л болж таарах байх. Ёстой нөгөө жоомоо алах гэж байгаад байшингаа шатаана гэдэг л болчих вий. НӨАТ бол манай улсад нэг 10-аад жил гаран хөгжиж байгаа. Хөгжүүлэлт нь хийгдэж байгаа ийм шинэ тутам татвар юм байгаа юм. Одоо АН-ынханд бол би баярлалаа гэж хэлмээр байдаг юм. Энийгээ анх зориулж гаргаж ирсэн ийм татварын шинэ ийм тогтолцоо. Өнөөдрийг хүртэл бид харин ч сайн хөгжүүлэлтийг хийлээ. Энэ Монгол одоо 175 улсын 1 нь манайх. Манайхаас доош НӨАТ-ын хэмжээтэй нэг 12 л улс байдаг юм байна. Харин НӨАТ-ын урамшуулал олгодог улс, яах вэ сугалаатай улс олон байгаа. НӨАТ-ын урамшуулал олгодог улс манайхаас өөр байхгүй, манайхаас өөр байхгүй шүү. Ингээд манайд байгаа НӨАТ-ын тогтолцоо маань төсвийн орлогын бараг 20, ирэх жил 27 хувийг бүрдүүлдэг ийм тогтвортой, ийм төсвийн орлогын бүрдүүлэгч энэ татвар болж ирсэн байгаа юм. Үүнээс бид энэ урамшуулал буцаан олголт гэдэг их эрс тэс 2 өөр ойлголт шүү. Албан татвар гэдгийгээ ч бас өөрөөр ойлгох хэрэгтэй. Албан татвар гэдэг болбол татвар төлөгч Монгол Улсын аюулгүй байдал, бие даасан төсвийн тогтвортой байдал

энд, төрийн алба, төрийн үйлчилгээний тогтвортой байх ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Нэмээд хариулчихъя, Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Энэ бүгдийг санхүүжүүлэх зорилгоор татвар бүрдүүлдэг. Үүнийхээ төлөө татвар төлөгч эргэлт буцалт ямар нөхцөлгүйгээр төлсөн татварыг албан татвар гэдэг. НӨАТ гэдэг нэмүү өртөг албан татвар. Тэр 2 хувь бол буцаан олголт биш энэ урамшуулал байхгүй юу, урамшуулал. Өөрөөр хэлбэл НӨАТ-ын тэр баримтыг цуглуулаад Доржийнх байна уу, Тулгаагийнх байна уу, хамаагүй цуглуулаад тэрийгээ, бүртгүүлснийхээ төлөө авч байгаа урамшуулал. Далд эдийн засгийг ил болгож байгаа. Дээрээс нь төсвийн орлогыг бүрдүүлж байгаа, үүний төлөө урамшуулал байхгүй юу. Ингээд урамшууллын хувь хэмжээг нэмэхээр мэдээж одоо ер нь татварын ямар ч төрлийг буулгана гэвэл үүнийг дэмждэггүй, үүнийг зөвшөөрдөггүй иргэн гэж байхгүй. Хэрвээ татварыг сая гишүүд бас хэлж л байна л даа. Татвар болон энэ Эрүүгийн хууль 2 дээр олон нийтийн санал асуулгаар ингэж чиглүүлж хөтлөгдөж явах юм бол энэ чиглэлийн яам, бодлогын яам, Засгийн газар гээд байгаад ч хэрэггүй. Эрүүгийн хууль дээр ямар шийтгэл авах вэ чи гэж санал асуулга авахад бас энэ зохимжгүй. Татвар дээр чинь хэдэн төгрөгийн татвар төлөх вэ гэж олон нийтийн санал асуулга уу. Үр дүн нь ямар гарах нь тодорхой шүү дээ.

Би тоон дүнгээр нь хэлэхэд 2 хувьд энэ жил болгон л нэмэгдэж байна. 2 хувийн урамшуулал бол нэг ирэх жил нэг 400 орчим тэрбум руу очно. Нэмээд 3 хувь гэх юм бол энэ чинь 1 их наяд болно, нийтдээ. 600 тэрбум төгрөгийн хэрвээ орон зай байгаа бол тэгээд төсвөөс тэрийг комбинсац хийх гэж байгаа бол үүнийг бага орлоготой иргэд үнэхээр шаардлагатай, зорилтот иргэд рүүгээ нийгмийнхээ тэр давхар луу чиглүүлэх

хэрэгтэй. Гэтэл энэ НӨАТ-ын энэ урамшуулал НӨАТ бүрдүүлэлт чинь ерөөсөө яг ийм байдаг. Юу вэ гэвэл ерөөсөө НӨАТ төлж байгаа иргэдийн 10 хувь нь нийт НӨАТ-ын орлогын 60 хувийг бүрдүүлдэг. Буцаагаад үүнээс нь 50 хувь нь комбинсац болгоод өгчих юм бол нөгөө өндөр орлоготой хэсэг рүүгээ л очно. Энэ чинь буцаад. Өнөөдөр төсөвт тийм орон зай байхгүй. Хэрэв байдаг сан бол тэрийг өндөр орлоготой хэсэг рүүгээ биш харин энэ халамж хэрэгтэй, тэтгэмж хэрэгтэй, бага орлоготой тэр хэсэг рүүгээ л энэ комбинсац энэ төсвийн бодлого чинь өөрөө тэр лүүгээ явж байх ёстой. Тэгэхээр иймэрхүү бодлогын уялдаа холбоогүй ийм зүйл гэнэт гарч ирсэнд их харамсалтай байна. Зүгээр тэгээд мэдээж энэ төсөв, энэ хууль батлах эрх бүхий дээд байгууллага маань Улсын Их хурал байдаг. Гишүүд, Улсын Их Хурал энэ дээр ухаалгаар хандаж зөв шийднэ байх гэж итгэж байна.

**Г.Тэмүүлэн:** Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн хүрээний мэдэгдэл бол дунд хугацааны бодлогын баримт бичиг. Энэ баримт бичгийг 2021 онд 3 удаа, 2022, 2023 онд 2, 2 удаа сольсон. Ингэж солихдоо дандаа нүүрсийг өндөр экспортлоно гэж орлогоо өндөр тавьж байгаад зардлаа нэмэгдүүлдэг. Ер нь ингэж төсвийн хүрээний мэдэгдлээ дунд хугацааны бодлогын баримт бичгээ жилд хэд хэдэн удаа сольдог ийм улс дэлхийд огт байхгүй. Тэгээд энэ жил ч гэсэн 5 сард 5 сарын 31-нд төсвийн хүрээний мэдэгдлээ баталсан. Тэгээд дөрөвхөн сарын дараа 22,9 их наяд байсан зардлаа 5 их наядар ингээд нэмэгдүүлээд ороод ирж байна л даа. Дахиад л нөгөө нүүрсээ нэмэгдүүлэх замаар орлогоо нэмэгдүүлж тэрнийгээ зардал гаргана л гэж шийдэж орж ирж байна. Тэгээд энэ бол үнэхээр 1 дүгээрт, бид нар энэ ирээдүйд бид нар аль болох хуримтлалыг бий болгох, Ирээдүйн өв санд хөрөнгө мөнгө байршуулж энэ ирээдүйдээ л зарцуулах ёстой тэр мөнгөө

өнөөдөртөө ингээд зарцуулж дуусаж байгаад харамсаад байгаа юм.

Энэ төсвийн хүрээний мэдэгдлээр инфляцын асуудал яригдана. 2022 оны 02 сарын 01-ний өдөр 350 мянган төгрөг байсан тэтгэврийг 500 мянга болгосон. Яг тэр өдөр 1 шуудай гурил 50 мянган төгрөг буюу 500 мянган төгрөгөөрөө 1 ахмад 10 шуудай гурил авдаг байжээ. Гэтэл өнөөдөр гурил 120 мянга болсон байна. Тэтгэврийг дунд нь 1 удаа нэмээд 550 мянга болгосон ч нөгөө 550 мянган төгрөгөөрөө 4 шуудай хагас гурил авдаг болж байна. Тэгэхдээ энэ хугацаанд 1 жил хагасын хугацаанд юу явсан бэ гэх дээр 140 хувийн инфляц явсан байна шүү дээ. Гурил дээр жишээ нь 140 хувийн. Тэгээд тэрнийгээ ингээд 8 хувь, 10 хувь гээд л ингээд л худлаа олон нийтэд мэдэгдээд л ингээд л яваад байгаа.

Тэгэхээр энэ гол асуудал энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр бас энэ инфляцын асуудлыг бас нэлээн сайн тооцож ярьдаг учраас энэ дээр мөнгөний бодлого, Монголбанкны мөнгөний бодлого дээрээс нь энэ Сангийн яам, Засгийн газраас явуулж байгаа төсвийн тэлэлттэй холбоотойгоор энэ инфляцаа яаж уялдуулж бага хэмжээнд барих вэ гэдэг асуудал чинь бас яригдах ёстой байхгүй юу. Гэтэл энд нэг хөгжлийн яамны нэг залуу суучихаад л энэ. Хэрвээ энд 5 их наядаар өнгөрсөн жилийнхээсээ бараг 8 их наяд байна уу, их наядаар зардлаа нэмж байна шүү дээ. Тэгээд энэ тохиолдолд л мөнгөний бодлого чинь жоохон хатуу байх ёстой байхгүй юу. Тэр уялдуулсан юмнууд нь энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр огт орж ярих тэгээд яригдахгүй ийм байдалтай л байгаад байна л даа. Тэгээд төсвийн орлого давж биелээд байгаа чинь 1 дүгээрт, тэр баахан бараа бүтээгдэхүүний үнэ өсөөд тэндээсээ татвар хураамж нэмэгдээд тэрнийгээ нэг гараараа ахмадуудад тэтгэвэр өгчхөөд, нөгөө гараараа инфляцаар бүгдийг нь хурааж авч байгаатай холбоотой. 2 дугаарт нь, гадаадын

импортыг тэр чигээр нь импортлож орж ирээд, гадаадын бараа бүтээгдэхүүнийг тэр чигээр нь инфляцтай нь импортлож орж ирээд тэрнээсээ төсвийн орлого нэмэгдэж орж ирж байгаа л ийм л үзүүлэлт шүү дээ. Бас нэг тийм айхтар сайндаа биш.

Тэгээд яах вэ. Нэг зүйлийг бас тодорхой хэлэхэд нүүрсний 50 саяын тонны экспорт баталгаатай биелнэ. Яагаад гэвэл 1 дүгээрт, энэ 6 сарын Ерөнхий сайдын айлчлал маш сайн үр дүнтэй болсон. 2 дугаарт нь, Ерөнхийлөгчийн айлчлал бас тодорхой хэмжээгээр яг энэ 2 орны айлчлалд бас тодорхой эерэг үр дүн авчирна гэж үзэж байна. Тийм учраас энэ 50 саяын экспорт би батална л гэж, биелэгдэнэ л гэж тооцож байгаа. Тэгэхдээ энэ болгоноор бүх мөнгөө бүгдийг нь үрчхэж болохгүй шүү дээ.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд хариулъя, асуултад.

**Б.Жавхлан:** Пүрэвдорж гишүүн ихэвчлэн санал хэлчих шиг боллоо. Би сүүлийнх дээр нь санаагаа хэлье. Нэмэгдсэн хэрээр үрчхэж болохгүй гэж байна. Тэгсэн мөртөө та иргэдийнхээ бодит яг орлогыг дэмжиж чадаж байгаа юм уу, үгүй юм уу гэж байна. Нэмэгдсэн хэрээрээ л зөвхөн иргэдийнхээ бодит орлогыг л дэмжихэд л зарцуулсан байгаа шүү дээ. Энэ 4,9 их наядын энэ өөрчлөлт чинь үндсэндээ 90 хувь нь ,90 хувь нь шүү бараг 94 хувь нь яг иргэдийн гар дээр очих, түүгээр дамжаад өрхийн орлогыг дэмжиж очиж байгаа цалин, тэтгэвэр, тэтгэмж, халамж гээд. 4,9 их наядын дөнгөж 300 тэрбум нь л хөрөнгийн зардал буюу хөрөнгө оруулалтууд нэмэгдэж байгаа. Өмнөх оноосоо өөрчлөлт нь. Тэгэхээр энэ бол энэ эдийн засгийнхаа өсөлт, энэ зардлын өсөлт, энэ боломж гарсан хэрээр яг өрхийн орлого ард иргэдийн гар дээр очиж байгаа ийм дорвитой бөгөөд бодитой л ийм өөрчлөлт гарч ирсэн. Тэрнээс биш төсөв сонгууль угтсан

баахан байшин барилга барьсан ийм төсөв огтоос биш ээ. Тэгэхээр таны санаатай нийцэж байгаа болов уу л гэж би ингэж бодож байна. Тийм.

Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэл гэдгийг би дахиад хэлье. Энд 9 макро тоо байдаг. 2 нь тусгай шаардлага байна, 2 нь инфляц бөгөөд ДНБ-ий нийт номинал дүн байгаа. Номинал дүн дотор та инфляц ярьж байна. Зөв өө, инфляц байгаа. Би түрүүн бас хэлсэн дахиад л хэлье. 60-74 гэдэг маань нэг 21 орчим хувиар өсөж байгаа юм, яг номинал дүн нь шүү. Энэ дотор инфляц нь 10 хувь байгаа, дунджаар 10 хувь байгаа. Цаана нь үлдэж байгаа 10-11 хувь нь бол яг бодит эдийн засгийн өсөлт дефлятор бол энд байгаа. Тэгэхээр энэ өсөлтийг бид бас үгүйсгэж болохгүй. Сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж байгаа хатуу ч арга хэмжээнүүд зөндөө авлаа, гадна талдаа ч бид нар хичээлээ. Зүгээр үнэхээр бид нар дотоод асуудлуудаа нэг юм шийдээд болоод байна. Их Хурал дээр ч сайн дэмжиж байгаа.

Гадна талд бол биднээс шалтгаалахгүй, бид дийлэхгүй юмнууд их олон байна.

**Г.Тэмүүлэн:** Пүрэвдорж гишүүн нэмж тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр тэр зардлуудын ихэнх нь тэтгэвэр, цалин, халамжид явж байгаа юм байна л даа. Тэгэхээр энэ төсөв дээр чинь яг тэр баялаг бүтээгчдээ дэмжсэн зүйл их ховорхон байна шүү дээ. Яг энэ их төсвийн тэлэлт чинь юуг дэмжээд байна вэ гэхээр энэ бүх бизнес бүгдээрээ л зөвхөн юу руу энэ төр лүү чиглэсэн тэр бизнес рүү л бүх юм нь явсан тийм зүйлийг л их дэмжээд байна л даа.

2 дугаарт нь, тэгээд сангаар дамжуулаад зээл баялаг бүтээгчдээ дэмжих зээл болох дээр нөгөө нэг дарга нар нь аваад байдаг учраас та нар болгоомжлоод тавиагүй байх л даа.

Тэгээд энэ ерөөсөө л энэ баялаг бүтээгчдээ яаж бага хүүтэй зээлийг тэрний комбинсацыг хүүгийн комбинсац ч юм уу, тэрийг яаж төлөх үү гэдэг замаар энэ асуудлыг шийдвэрлэх тэр зүйлүүд чинь их ховорхон байгаад байна шүү дээ.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Манай татварын орлогын ер нь 90 хувийг 100 компани л бүрдүүлдэг юм. Эдгээр улсуудтайгаа уулзаад, судалгаа аваад ингэж байхад нэг айхтар төрөөс хөнгөлөлттэй зээл хүсээд байгаа юм нь их бага байдаг юм байна лээ. Гол нь эдийн засгаа тогтвортой байгаач, бодлого өөрөө тогтвортой байгаач, татварын орчин чинь тогтвортой байгаач, ил тод байгаач, төрөөс явуулж байгаа энэ төсвийн бодлого, мөнгөний бодлого нь уялдаатай ойлгомжтой байгаач гэж их илүү хүсдэг болсон байна. Тэр хүрээнд энэ Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлого маань яг энэ рүү чиглэж байгаа. Яг баялаг бүтээгч нар бизнесийн орчныг нь сайжруулах чиглэл рүү шүү. Энэ хүрээнд бид нар 24 онд анх удаа шүү, эрчим хүчний салбарт өөрөөр хэлбэл шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эрчим хүчний сэргэлтийн хүрээнд нийтдээ 1 ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу? Нэрсийг авъя. Батсуурь гишүүнээр тасаллаа. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батсуурь:** Баярлалаа. Төсвийн хүрээний мэдээлэл, төсвийн төсөөлөл төсөв ярихаар нүүрс, бензин тос гээд л ингээд ярьдаг. Гол санаа бол энэ хөдөө аж ахуйн салбар малын гаралтай түүхий эд, махны үнийг чөлөөлмөөр байна.

Засгийн газар энэ төв орон газрын хүмүүсийн жагсаал цуглаан, инфляц гэдгээс айж, энэ махны үнийг барьдаг Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлого тэгээд орон нутгийг дэмжих энэ асуудал төвлөрлийг сааруулах, энэ түгжрэлийг сааруулах, инфляц, энэ их хотын нерв гээд ингээд олон зүйл байдаг. Гэтэл орон нутагт энэ төвлөрлийг сааруулах, эдийн засгийн бааз суурь өсөх гол шалтгаан бол хөдөө аж ахуйн салбар түүн дотроо махны л үнэ байгаа шүү дээ. Тийм учраас гадагшаа гарч байгаа энэ мах, махны экспортыг богино хугацаанд хийх, хойшоо Оростой хийх махны татварыг тэглэх багасгах, мөн энэ махны экспортыг зоригтой дэмжиж, энэ махны үнийг өсгөх хэрэгтэй.

Дээр нь тэгж байж энэ орон нутгийн эдийн засаг чинь сэргэнэ. Мэдээж боломж багатай тэтгэвэр, тэтгэмжтэй, тэтгэвэр тэтгэмж гэдэг юм уу өрхийн орлого багатай газрыг энэ шийдэж болно шүү дээ. Нөөцийн махаараа гэдэг юм уу. Өнөөдөр бид нар даралтын эмийг өндөр үнэтэй бичиж өгөөд яг авахдаа тэр боломж муутай хэсэг бол хямд үнэтэй авч болдог шүү дээ. Тэгэхгүйгээр нийт нялзаагаад энэ хөдөө аж ахуйн салбарыг боомлоод тэгээд ярих болохоор төсвийн орлого тэлэлтийг ярих болохоор нэг нүүрс ярьдаг. Импорт ярих болохоор нэг бензин тос, түлш ярьдаг. Тийм учраас энэ махны үнийг чөлөөлөх юм бол хөдөө аж ахуйн салбар аяндаа тэлнэ ээ, аяндаа тэлнэ. Тэгэхээр Засгийн газрын энэ зоригтой арга эмжээг яаралтай авах хэрэгтэй байна гэж ингэж үзэж байгаа юм.

Дээр нь төсвийн орлогыг 100 орчим компани, 90 орчим хувийг нь бүрдүүлж байна гэж хэлж байна. Тэгэхдээ энэ голдуу л төвлөрсөн газар. Эрдэнэт, Улаанбаатар, Дархан гэх нутагт. Хөдөөд ийм том үйлдвэрүүдийг бий болгох дараагийн 10 үйлдвэр, 50 үйлдвэр төсвийн орлогыг бүрдүүлдэг тэр 90 хувьд орох энэ нөхцөл байдлыг орон

нутагт бий болгож байж л энэ төвлөрөл саарна. Өнөөдөр бүх зүйлийг төвлөрүүлэн татаж байна. Орлого нь ч тэр хэмжээгээрээ төвөөсөө бий болгогчоо байна. Тийм учраас энэ махны үнийг чөлөөлөх асуудал дээр л Засгийн газар онцгой анхаарах хэрэгтэй байна, онцгой анхаарах хэрэгтэй. Зүгээр төв орон газруудад махны үнэ өслөө, инфляцыг нэмэгдүүлнэ гэсэн ийм байдлаар асуудалд дандаа ханддаг. Ингэж хөдөө аж ахуйн салбараа сэргээхгүй бол бид нар нэг уул уурхай, энэ аж үйлдвэрийн бүтээгдэхүүн гэдэг эдгээр зүйл дээр анхаараад эдийн засаг дорвитой солонгорч өгөхгүй. Уул уурхайгаасаа салж өгөхгүй. Энэ тал дээр дараа дараагийн энэ төсөв, төсөв дагасан хуулиуд дээр онцгой анхаарч өгмөөр байна гэсэн энэ санааг илэрхийлж байна.

**Г.Тэмүүлэн:** Батсуурь гишүүнд баярлалаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж гишүүд үг хэлж, санал хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт. 50, 50 хувиар. Баделхан гишүүн, Баделхан гишүүний микрофоныг өгье.

**Х.Баделхан:** Санал хураалтыг дахин хураалгаж өгнө үү. Сая минийх ажилласангүй.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Баделхан гишүүний гаргасан горимын

саналаар. Баделхан гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

72,7 хувиар дэмжигдлээ.

Баделхан гишүүний гаргасан санал дэмжигдсэн учраас төсвийн хүрээний мэдэгдлийг хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт, гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтад нийт 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжин 72,7 хувиар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ажлын хэсэг болоод Байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

Хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд манай Байнгын хорооны гишүүдээс Сандаг-Очир гишүүнээ танилцуулах уу? Сандаг-Очир гишүүнээр. Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

11.35 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**